

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



ОРЧИН ҮЕИЙН МЕНЕЖМЕНТИЙН СИМУЛЯЦИ “Business Management Game”

(Туршилт хичээл)
2026.9.8

2026 он

1) Сургалтын зорилго:

Энэхүү сургалтаар Японы бизнесийн сургуулиуд болон албан байгууллагуудын сургалт хөгжлийн хөтөлбөрт нэвтрээд буй орчин үеийн “Бизнесийн удирдлагын симуляци (Business Management Game)” программыг туршиж үзэх боломжийг олгоно.

Васэдагийн Бизнесийн Сургуулийн хяналт дор боловсруулсан BMG программ нь хийсвэр орчинд компани удирдаж туршлага хуримтлуулан менежментийн чадварыг цогцоор нь хөгжүүлэх боломжтой.

Оролцогч өөрийгөө компанийн удирдлага гэж төсөөлөн, удирдлагын өнцгөөс шийдвэр гаргах бөгөөд шийдвэрийн үр дүнг шууд дүгнэн харж туршлага хуримтлуулах юм.

Энэхүү программыг Японы шинэ үеийн компанийн удирдагчдыг бэлтгэхэд ашиглаж байна. Та энэ сургалтад хамрагдсанаар орчин үеийн “практик сургалтын агуулга”-ыг туршиж үзэх боломжтой.

2) Хугацаа: 2026.9.8 (Мягмар, 09:30-13:00)

3) Хамрагдах хүн: “Business Management Game”-ийг сургалт хөгжлийн хөтөлбөртөө нэвтрүүлэх сонирхолтой их дээд сургуулийн багш нар, сургалтын албаныхан, байгууллага аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтнууд, сургалт хөгжлийн менежерүүд

4) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

※ Зөөврийн компьютертой ирнэ үү!

5) Сургалтын төлбөр: 120,000 төгрөг

6) Хичээл заах багш: Сүдо Шо



“Сүкорэ” ХК-ийн ТУЗ-ийн дарга

LINE корпорацид интернэт сурталчилгааны газрын захирлаар ажиллаж, бизнес болон багийн удирдлагад ажилласан туршлагатай. Үүний дараа Дижитал Агентлагт төрийн байгууллагуудын дижитал шилжилтийг хариуцан ажилласан.

2021 онд “Сүкорэ” компанийг үүсгэн байгуулж, одоогийн байдлаар хувийн болон дээд боловсролын байгууллагуудын дараагийн үеийн удирдагчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж байна.

Васэда Их Сургуулийн Бизнесийн Сургууль.

Энэтхэгийн Бизнесийн Удирдлагын Их Сургууль.



Абико Жүня

“Сүкорэ” ХК-ийн “Сүкорэ” ХК-ийн Гүйцэтгэх захирал, Бизнес хөгжүүлэлтийн захирал

LINE корпорацид бизнес хөгжүүлэлт, борлуулалт, харилцагчийн үйлчилгээний чиглэлээс эхлэн, онлайн болон жижиг дунд бизнест чиглэсэн зар сурталчилгааны бизнесийн баг байгуулж, тогтвортой болох хүртэл удирдсан.


Ахлах менежер болж үйл ажиллагааг удирдан, бүтээгдэхүүний стратеги болон багийн бүтцийг бүхэлд нь хариуцан ажиллаж. Тэгээс эхлэн жилд 10 тэрбум иенээс дээш эргэлттэй бизнес болгон хөгжүүлсэн.

2026 онд Сколе ХК-д ажиллаж эхлэн, гүйцэтгэх захирал — бизнес хөгжүүлэлтийн газрын дарга албан тушаалд томилогдож. Үйлчилгээний бизнес хөгжүүлэлтийг удирдахын зэрэгцээ, багшийн хувьд мэдлэг туршлагаа системчлэх, шинэ үеийн боловсон хүчнийг бэлтгэх ажилд оролцож байна.

Доккёо их сургуулийн Гадаад хэлний факультетыг төгсөж, Токиогийн их сургуулийн Мэдээллийн технологийн магистрын хөтөлбөрийг дүүргэсэн.

7) Сургалтын хөтөлбөр:

Өдөр	Сэдэв	Агуулга	Цагийн хуваарь
9 сарын 8 /Мягмар/	(1) Бизнесийн симуляцийн туршлага (2.5 цаг)	3-4 хүний бүрэлдэхүүнтэй багт хуваагдан, хийсвэр компанийг удирдах даалгавар гүйцэтгэнэ. - Компьютер ашиглан онлайн орчинд компанийн удирдлагын туршлага хуримтлуулна. Та үйлдвэрлэлийн компанийн захирал болж, өөрчлөгдөн буй зах зээл, өрсөлдөгчдийн үйл ажиллагааг шинжлэн, 5 жилийн хугацаанд үйлдвэрлэл, судалгаа, боловсруулалт, ажилтан сонгон шалгаруулалт, маркетинг, санхүү зэрэг менежментийн олон төрлийн шийдвэр гаргана. - BMG нь орчин үеийн бодит өрсөлдөөнт орчныг дуурайхын зэрэгцээ график, рейтинг зэрэг ойлгомжтой үйлдлийн дэлгэц, багуудын хооронд өрсөлдөх системийг нэвтрүүлснээр оролцогчдын сонирхол, өрсөлдөх сэтгэлгээ, сурах эрмэлзлийг нэмэгдүүлдэг.	Хичээлийн цаг 09:30-12:30
	(2) Аж ахуйн нэгж, дээд боловсролын байгууллагуудад нэвтрүүлсэн жишээ (0.5 цаг)	- Япон дахь аж ахуйн нэгж болон дээд боловсролын байгууллагуудад нэвтрүүлсэн жишээнүүдийг танилцуулна. - Их дээд сургууль, мэргэжлийн сургуулиудад манлайллыг хөгжүүлэх, бизнесийн мэдлэгийг гүнзгийрүүлэх зорилгоор хичээл, семинарт ашиглаж байгаа бөгөөд суралцагчдын идэвх санаачилга, практик ур чадварыг дээшлүүлэх арга хэрэгсэл болж өндөр үнэлэгдэж байна. Мөн томоохон болон гарааны бизнесийн компаниудад шинэ менежерүүдэд зориулсан манлайллын сургалт, залуу ажилтнуудад зориулсан бизнесийн суурь мэдлэгийн сургалтад нэвтрүүлж, бизнесийн сэтгэлгээ болон багаар шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх үр дүнтэй арга болж байна. Боловсролын арга зүйгээ байнга сайжруулж байдаг та бүхэнд шинэ мэдлэг, ойлголт өгнө гэдэгт итгэлтэй байна.	Завсарлага 10:50-11:00 /10 мин/



8) Бүртгэл: Доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



9) Холбоо барих:



Утас: 7511-0879(Ext.3) , 8063-0879



Э-Мэйл: business@japan-center.edu.mn

Цахим хуудас: www.japan-center.edu.mn



Фейсбүүк хуудас: www.facebook.com/Mojc.business

